



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 9 сарын 31 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Туул голын сав газрын захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн, нийт 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөгийн балансын үнэ, 2,450,000.00 (хоёр сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Туул голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямдорж, Хан хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга Б.Хашмаргад нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 01 дүгээр сарын 31 өдрийн
ХА. дугаар тогтоолын хавсралт

**ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНААС ХАН ХЭНТИЙН УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Х/Н	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
Туул голын сав газрын захиргаа								
3	Ариун цэврийн байгууламж (Яармагийн зүүн урд байршилтай)	5/17/2022	ш	1	7,350,000.00	7,350,000.00	857,500.00	6,492,500.00
4	Ариун цэврийн байгууламж (Маршалын гүүрний баруун урд байршилтай)	5/17/2022	ш	1	7,350,000.00	7,350,000.00	857,500.00	6,492,500.00
5	Ариун цэврийн байгууламж (Беегийн овооны урд байршилтай)	5/17/2022	ш	1	6,300,000.00	6,300,000.00	735,000.00	5,565,000.00
НИЙТ ДҮН						21,000,000.00	2,450,000.00	18,550,000.00

төгсгөвөр